

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны
санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД:

ДУА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Дарга,тэргүүлэх аудитор:

Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг:

Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг:

Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Ихбаяр

Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Цахим хаяг: oyun-erdenet@audit.gov.mn

Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



1. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/07

Мандлговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайланг /ДУА-2024/1/НА-СТА-ТЕЗ/-г нэг дүгээр хавсралтаар, аудитаар илэрсэн зөрчил, төсөв захирагчийн харьяа байгууллагад хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан үр дүнгийн талаар 2024 оны 11 сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Энхтайван/, Ерөнхий санхүүч /С.Адьяасүрэн/-д тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2024 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Д.Ихбаяр/, аудитор /Т.Оюун-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ



Агуулга

1. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ	1
1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. АУДИТ ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Албан шаардлага	11
3.2 Зөвлөмж	11
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ТХДЖТ	Төв халхын дуулалт жүжгийн театр
БХС	Байгаль хамгаалах сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
СДОА	Сум дундын ойн анги
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
МХС	Мал хамгаалах сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗС	Тусгай зориулалтын сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эмийн эргэлтийн сан



1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.МӨНХБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар Өлзийт, Дэрэн сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дэрэн, Говь-Угтаал, Өлзийт, Сайнцагаан сумдын Засаг даргын Тамгын газрууд зэрэг нийт 6 санхүүгийн тайлан “Хязгаарлалттай”, Дундговь-Ус ОНӨАТҮГ “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн авлага, өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй, эд хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллогыг чанаргүй хийсэн, тооллогын явцад хяналт тавиагүй, албан хаагчдад цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг зөрүүтэй тооцож олгосон, төсвийг зориулалт бусаар үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн нь материаллаг дүнтэй бөгөөд санхүүгийн тайланд бүрэн тархаагүй.

Эдгээр залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 1.4 дахин их, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны эхнээс орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.5 дахин өссөн, ахмадын сангийн үлдэгдлийг тухайн төсвийн байгууллагын хөтөлбөр арга хэмжээ болгон тайлагнадаг болсон асуудлууд байна.

Уг үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн заавар журамтай холбоотой 7,225.8 сая төгрөгийн дараах зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

1. ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх онтой харьцуулахад нийт зөрчил 5,247.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Тодруулбал залруулсан алдаа 569.7 сая төгрөгөөр, төлбөрийн акт 17.0 сая төгрөгөөр, зөвлөмж 705.0 сая төгрөгөөр буурсан боловч албан шаардлага 6,539.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Албан шаардлагаар өгсөн зөрчлийн дүнг агуулгаар нь авч үзэхэд **“Орон нутгийн хөгжлийн сан”**-гийн төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотой зөрчил 5,806.8 сая төгрөг буюу 72.5 хувийг эзэлж байна.
2. Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлээгүй “Луус”, “Дэлгэрхангай” сумаас бусад 7 сумын 822.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 5 сумын 158.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.
3. Гурвансайхан, Луус, Сайхан-Овоо, Өндөршил сумдын ХХС-ийн зээлийн авлага буурсан боловч Өндөршил, Адаацаг, Дэлгэрхангай, Дэрэн сумдаас бусад 10 суманд хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг нөхөн төлүүлэхээр 88.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.
4. Өмнөх аудитаар өгсөн 30.4 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 21 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, аудитаар илэрсэн 319.8 сая төгрөгийн 3 байгууллагын 4 зөрчилтэй асуудлыг агуулга шинж чанарын хувьд материаллаг, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

;



Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Засаг дарга Засгийн газрын хэрэг эрхлэх газартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хийсэн үнэлгээгээр 93.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,357,548.4	42,508,803.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,531,229.7	16,130,554.6
33	АВЛАГА	5,666,295.1	7,470,402.5
35	БАРАА МАТЕРИАЛ	4,163,309.4	4,223,075.6
36	НӨӨЦИЙН БАРАА	93,750.1	73,580.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	12,902,964.0	14,611,190.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	92,658,324.2	97,906,905.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	92,658,324.2	97,906,905.9
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	68,493,624.8	73,611,169.3
39300	Биет бус хөрөнгө	24,164,699.4	24,295,736.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	126,015,872.5	140,415,709.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,669,040.1	15,479,392.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,354,354.0	1,648,971.7
41300	Өглөг	762,210.9	1,201,698.7
41400	Урьдчилж орсон орлого	592,143.1	447,273.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,314,686.1	13,830,421.3
42200	Урт хугацаат зээл	15,314,686.1	13,830,421.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	109,346,832.4	124,936,316.3
51	Засгийн газрын хувь оролцоо	109,346,832.4	124,936,316.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	41,921,503.7	44,494,928.6
51200	Хуримтлагдсан үр дүн	39,740,175.3	52,721,691.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,685,153.4	27,719,696.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	126,015,872.5	140,415,709.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47,037,765.8	65,388,722.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,971,191.9	19,468,415.5
110	Орлогын албан татвар	5,363,400.0	14,954,931.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	5,652,018.7	7,629,396.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(361,298.4)	(406,659.6)
1103	ААН-ын орлогын албан татвар	72,679.7	7,731,294.9
113	Хөрөнгийн албан татвар	1,538,022.2	1,703,121.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,069,769.8	2,811,262.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,184,498.3	39,178,211.8
120	Нийтлэг татварын бус орлого	11,324,378.4	10,332,531.7
121	Хөрөнгийн орлого	48,665.0	278,404.5
122	Тусламжийн орлого	-	38,745.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	19,811,454.9	28,528,530.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,882,075.6	6,742,095.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	30,311,022.6	33,906,201.8



21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,311,022.6	33,906,201.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,853,984.7	30,732,722.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,584,127.0	8,395,276.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	687,420.6	1,029,249.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	707,724.8	940,077.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,573,074.8	1,155,695.8
2105	Нормативт зардал	86,362.1	94,924.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	263,095.0	400,461.0
2107	Томилолт, зочны зардал	231,704.2	346,488.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,037,977.6	8,015,122.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,682,498.6	10,355,428.1
212	ТАТААС	873,582.6	2,217,730.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,583,455.3	955,748.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	16,726,743.2	31,482,521.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,006.2	5,833.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	89,577,160.2	31,511,427.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(72,849,410.9)	(23,073.2)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	43,802,795.0	64,771,425.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	9,329,996.4	19,223,796.8
110	Орлогын албан татвар	5,666,720.3	14,650,740.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	5,652,018.7	7,629,425.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(361,298.4)	(406,659.6)
1103	ААН-ын орлогын албан татвар	376,000.0	7,427,974.6
113	Хөрөнгийн албан татвар	1,538,022.2	1,703,121.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,125,254.0	2,869,934.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	378,501.1	377,793.6
1181	Газрын төлбөр	693,027.3	1,592,582.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,053,725.6	899,179.3
1183	Бусад татвар	-	380.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,397,141.2	38,813,957.3
120	Нийтлэг татварын бус орлого	7,537,021.4	9,977,549.0
121	Хөрөнгийн орлого	48,665.0	278,404.5
122	Тусламжийн орлого	-	29,473.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	19,811,454.9	28,528,530.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,075,657.3	6,733,671.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,438,296.5	34,908,926.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,438,296.5	34,908,926.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,178,807.5	29,222,748.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,373,052.8	9,858,223.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	924,876.3	1,224,357.8



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,584,466.7	1,287,186.6
2104	Хангамж, бараа материалын зардал	2,780,964.3	2,949,047.0
2105	Нормативт зардал	189,142.0	207,972.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	670,713.4	455,608.6
2107	Томилолт, зочны зардал	233,354.2	346,291.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,855,066.4	7,658,501.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,567,171.5	5,235,560.1
211	ХҮҮ	-	2,540,400.4
212	ТАТААС	855,389.9	2,163,178.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,404,099.2	982,598.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,364,498.5	29,862,499.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,141,328.9	22,397,024.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,141,328.9	22,397,024.7
2200	Дотоод эх үүсвэрээр	16,141,328.9	22,397,024.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(16,141,328.9)	(22,397,024.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,240,712.0)	(1,866,149.8)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,240,712.0	1,866,149.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,017,542.5)	5,599,324.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,548,772.2	10,531,229.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,531,229.7	16,130,554.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,076,429.5	185,076,429.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,080,582.5)	(2,080,582.5)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	182,995,847.0	182,995,847.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(609.3)	(609.3)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(2,007,344.7)	(2,007,344.7)
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,208,350.2	1,208,350.2
9	Тайлант үеийн үр дүн	(72,849,410.9)	(72,849,410.9)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,346,832.4	109,346,832.4
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,346,832.4	109,346,832.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,004,589.0	13,004,589.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,351,421.4	122,351,421.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	34,543.1	34,543.1
17	Өмчид гарсан өөрчилөлт	2,573,424.9	2,573,424.9



19	Тайлант үеийн үр дүн	(23,073.2)	(23,073.2)
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	124,936,316.3	124,936,316.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,897,828.0	46,677,179.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,749,479.5	28,487,860.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,725,353.7	23,606,783.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,596,096.2	8,327,305.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,093,866.5	1,021,325.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,339,706.3	6,185,389.4
2104	Хангамж, бараа материалын зардал	947,530.8	858,602.2
2105	Нормативт зардал	112,612.9	111,294.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,180,213.4	1,106,056.7
2107	Томилолт, зочны зардал	354,298.9	321,746.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,482,006.8	1,272,298.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,619,021.9	4,402,763.2
211	ХҮҮ	2,540,400.4	2,540,400.4
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	2,540,400.4	2,540,400.40
212	ТАТААС	1,495,165.0	1,477,956.4
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,147,566.9	1,136,778.3
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	347,598.1	341,178.1
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	347,598.1	341,178.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	988,560.4	862,720.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	325,830.0	258,508.9
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	325,830.0	258,508.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	662,730.4	604,211.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,355,817.5	16,784,419.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,792,531.0	1,404,900.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,897,828.0	46,516,205.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,875,387.3	11,563,002.4
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,889,155.9	32,218,825.4
320001	Орон нутгийн төсвөөс	34,889,155.9	32,218,825.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,133,284.8	2,734,377.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,215,545.0	1,066,939.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,938,160.2	1,667,438.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,196,867.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,035,893.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,486,715.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,482,915.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,314,535.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,755.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,476.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,233.3
2104	Хангамж, бараа материалын зардал	66,144.0
2105	Нормативт зардал	576.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,449.3
2107	Томилолт, зочны зардал	23,904.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,119.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	822,876.7

ДУА-2024/1/НА-СТА-ТЕЗ



213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,380.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,313.8
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	131,066.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,800.0
2200	Дотоод эх үүсвэрээр	3,800.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,486,715.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,486,715.1
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(0.6)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9.0

3. АУДИТ ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 38 төсвийн байгууллага, 18 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 32 тусгай зориулалтын сан, 15 сумын нэгтгэсэн тайлан, аймгийн Засаг дарга нийт 104 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 66 байгууллагыг аудитад хамруулан, 37 санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 66 байгууллагыг түүвэрт хамруулж, 37 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Өөрчлөлтгүй” 30, “Хязгаарлалттай” 6 /Дэрэн, Өлзийт сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Аймгийн ИТХ, Сайнцагаан, Дэрэн, Говь-Угтаал сумын ЗДТГ/, “Сөрөг” 1 /Дундговь-Ус ОНӨАТҮГ/ дүгнэлт гаргасан байна.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 10,677.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,253.5 сая төгрөгийн 97 алдааг аудитын явцад залруулж, 166.5 сая төгрөгийн зөрчилд 47 төлбөрийн акт тогтоож, 7,669.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 189 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн 30.4 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 21 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 238.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 34 зөвлөмж хүргүүлж, 319.8 сая төгрөгийн 4 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 78.9 хувийг залруулагдаагүй, 21.1 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчийн 15 санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” 13, “Хязгаарлалттай” 2 /Дэрэн, Өлзийт сумдын санхүүгийн нэгтгэсэн тайлан/ дүгнэлт гаргасан байна.

Аудитаар нийт 1,584.0 сая төгрөгийн 56 алдаа, зөрчил илрүүлснээс 532.0 сая төгрөгийн 13 алдааг аудитын явцад залруулж, 3.3 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 915.7 сая төгрөгийн 28 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн 8.6 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 124.3 сая төгрөгийн 11 зөрчилд зөвлөмж өгсөн.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэг 38 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 18 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 20 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан. Дүгнэлт гаргасан байгууллагуудаас “Өөрчлөлтгүй” 16, “Хязгаарлалттай” 4 /Аймгийн ИТХ, Сайнцагаан, Дэрэн, Говь-Угтаал сумын ЗДТГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,813.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,190.0 сая төгрөгийн 51 алдааг аудитын явцад залруулж, 72.7 сая төгрөгийн 31 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 538.8 сая төгрөгийн 93 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн 2.5 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 10 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 9.6 сая төгрөгийн 12 алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн аудитаар



Харьяа 18 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд аудит хийж, 16 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан 2 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан. Дүгнэлт гаргасан байгууллагуудаас “Өөрчлөлтгүй” /”Мандалын гэгээ ХТГ” ОНӨААТҮГ/, “Сөрөг” /Дундговь-Ус ОНӨААТҮГ/ гарсан байна.

Аудитаар нийт 1,237.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 511.1 сая төгрөгийн 29 алдааг аудитын явцад залруулж, 0.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 382.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 27 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн 19.3 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 44.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж хүргүүлж, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 280.3 сая төгрөгийн 2 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 32 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Аудитаар нийт 6,026.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 19.8 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 89.7 сая төгрөгийн зөрчилд 12 төлбөрийн акт тогтоож, 5,817.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 39 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 8 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 60.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж хүргүүлж, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 39.5 сая төгрөгийн 2 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 4 зөрчил¹ илэрснээс зөрчил арилгах хугацаатай 1 албан шаардлага, хуулийн хэрэгжилттэй холбоотой 3 зөвлөмж өглөө.

3.1 Албан шаардлага

1. Дэрэн сумын Засаг дарга, санхүүгийн алба нь 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараалан “Хязгаарлалттай” дүгнэлт авч, дотоод хяналтыг сайжруулаагүй.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.5.-д /Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх/, Төсвийн тухай хуулийн 14.2.10-д /Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх./, 36.6-д /Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ./ заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Дэрэн сумын санхүүгийн сахилга батыг сайжруулах талаар зөвлөмж, чиглэл өгч, дотоод аудитыг хэрэгжүүлж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллах хугацаатай албан шаардлагыг Дундговь аймгийн Засаг даргад хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1. ***Илрүүлэлт :***

ТЕЗ-ын харьяа байгууллагуудын халаалтын төлбөр 58.0 сая төгрөг байна. Харин улсын төсвөөс санхүүждэг Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 858.9 сая төгрөгийн халаалтын өрийг салбарын тайландаа тайлагнажээ. Тайлант онд дээрх байгууллагууд дээр өмнөх жилүүдэд үүссэн насжилт өндөртэй 41 байгууллагын 281.2 сая, 2022 онд 32 байгууллагын 141.7 сая буюу нийт 422.9 сая төгрөгийн өрийг аймгийн засаг дарга сангаас тус тус барагдуулсан байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Халаалтын өр төлбөр үүсэж байгаа шалтгаан нь дулааны эрчим хүчээр хангаж байгаа байгууллагууд жилийн дундуур хэрэглэгчдэд борлуулах эрчим хүчний тарифаа нэмэгдүүлдэг, мөн төсөв захирагч нар халаалтын зардлыг хэмнэх чиглэлээр өдөр тутмын халаалтын чанарт хяналт тавих, тоолууржуулах гэх мэт арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой бөгөөд энэ нь төсвийг хэмнэлтгүй үр ашиггүй зарцуулах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж :

Дулаан нийлүүлэгч байгууллагуудын халаалтын чанарт хяналт тавьж, байгууллагын халаалтын системийг тоолууржуулан, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж зардлыг хэмнэж, өр төлбөр үүсгэхгүй байх ажлыг харьяа төсөвт байгууллага болон орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг нь санхүүжүүлж байгаа байгууллагуудын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцон, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах.

Зөвлөмжийн биелэлт: Зөвлөмжийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.

2. Илрүүлэлт :

ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх онтой харьцуулахад нийт зөрчил 5,247.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. ТЕЗ-ийн 2023 оны нэгтгэсэн тайлан тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх онтой харьцуулахад залруулсан алдаа 569.7 сая төгрөгөөр, төлбөрийн акт 17.0 сая төгрөгөөр, зөвлөмж 705.0 сая төгрөгөөр буурсан боловч албан шаардлага 6,539.2 төгрөгөөр, нийт зөрчил 5,247.6 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Албан шаардлагаар өгсөн зөрчлийн дүнг агуулгаар нь авч үзэхэд нийт зөрчлийн дийлэнх 5,806.8 сая төгрөг буюу 72.5 хувийг ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотой зөрчил эзэлж байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотой зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, зөрчил гарсан учир шалтгаан, үр дагаврыг тооцож, зөрчлийг арилгах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг тайлант хугацааны явцад хийж, жилийн эцсийн тайлан гарахаас өмнө хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах.

Зөвлөмжийн биелэлт: Зөвлөмжийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.

3. Илрүүлэлт :

ТЕЗ-ын харьяа байгууллагуудын төсөв захирагч нар “Албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэж хүлээн авах” эрх бүхий албан тушаалтнуудын нэмэгдэл цалинг ажлын ачаалал, мэдүүлэг гаргах албан тушаалтны тоо, ажлын үр дүн зэргийг харгалзалгүй, харилцан адилгүй олгож байна. Тухайлбал; Сумдын ИТХ-ын хувьд 7 сум 10 хувь, 1 сум 15 хувь, 4 сум 20 хувь, 3 сум 30 хувиар, ЗДТГ-уудын хувьд 5 сум 10 хувь, 5 сум 20 хувь, 1 сум 25 хувиар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 10 хувь, Орон нутгийн өмчийн газар 30 хувь, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 15 хувиар тус олгож байна.

Өгсөн зөвлөмж:

ТЕЗ-ын харьяа байгууллагуудын албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж хүлээн авах эрх бүхий албан тушаалтнуудын нэмэгдэл цалинг харилцан адилгүй олгож байгаа байдлыг судалж байгууллагын онцлог бүтэц орон тоо, мэдүүлэг гаргах албан тушаалтны тоо, ажлын ачаалал, ажлын үр дүнг харгалзан ижил тэгш олгох асуудлаар төсөв захирагч нарыг удирдлагаар хангаж төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах;

Зөвлөмжийн биелэлт: Зөвлөмжийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Математик тооцоололтой холбоотой		Үүнээс			
											Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	1	0.6	1	0.6		-		-			1	0.6		
ТТЗ	13	532.0	5	299.8	3	31.8	5	200.4			13	532.0		
ТШЗ	51	1,190.0	7	16.7	16	667.5	27	505.8	1	0.1	51	1,190.0		
ОНӨААТҮГ	29	511.1	7	149.1	12	186.8	9	175.0	1	0.2	29	511.1		
ТЗС	3	19.7	1	7.3			2	12.4			3	19.7		
Дүн	97	2,253.5	21	473.5	31	886.2	43	893.6	2	0.2	97	2,253.52		

Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	1	15.4	0	-	1	15.4		-				
ТТЗ	20	125.0	3	3.3	13	117.0	4	4.6				
ТШЗ	95	381.2	29	68.5	60	303.1	6	9.6				
ОНӨААТҮГ	26	369.7	1	0.8	23	344.5	2	24.4				
ТЗС	5	270.9	1	1.2	4	269.7	0	-				
Нийт дүн	147	1162.2	34	73.8	101	1,049.8	12	38.6	0	0	0	0



Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын нийцлийн аудитын асуудал :

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ТТЗ	3	-			2	-	1	-				
ТШЗ	25	2.5			15	-	3	-	7	2.5		
ТЗС	1	-					1	-				
ОНӨААТҮГ	3	-			2	-	1	-				
Дүн	32	2.5	-	-	19	-	6	-	7	2.5	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ТЕЗ	4	-		-	1	-	3	-	0	-		-
ТТЗ	19	922.7		-	12	794.4	6	119.7	1	8.6		-
ТШЗ	26	239.8	2	4.2	18	235.7	3	-	3	-		-
ОНӨААТҮГ	8	357.1		-	2	37.7	2	19.7	2	19.3	2	280.3
ТЗС	59	5,740.1	11	88.5	36	5,552.0	2	60.0	8	-	2	39.5
Дүн	116	7,259.6	13	92.7	69	6,619.8	16	199.4	14	27.9	4	319.8
Нийт дүн	148	7,262.1	13	92.7	88	6,619.8	22	199.4	21	30.4	4	319.8



Хавсралт №1

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

(сая.төгрөгөөр)

Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр					Нийт алдаа, зөрчил		Залруулсан		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
	Түүвэрт хамрагдсан	Дүгнэлт														Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТЕЗ			1			6	16.0	1	0.6	-	-	2	15.4	3	-		-		-
ТТЗ		13	2			56	1,584.0	13	532.0	3	3.3	28	915.7	11	124.3		-	1	8.6
ТШЗ	18	16	4			197	1,813.6	51	1,190.0	31	72.6	93	538.8	12	9.6		-	10	2.5
ОНӨААТҮГ	16	1		1		66	1,237.9	29	511.1	1	0.8	27	382.3	5	44.1	2	280.3	2	19.3
ТЗС	32					67	6,026.4	3	19.7	12	89.7	39	5,817.4	3	60.0	2	39.5	8	-
НИЙТ ДҮН	66	30	7	1	-	392	10,677.9	97	2,253.5	47	166.5	189	7,669.6	34	238	4	319.8	21	30.4

